**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДГА-2021/70/СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он


Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048891
Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 5
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 5
3. Аудитын тайлан ........ 16
3.1. Ерөнхий зүйл ........ 16
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 16
3.4. Материаллаг байдал ........ 17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 18
3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19
3.9. Аудитын илрүүлэлт ........ 19
Залруулсан алдаа ........ 19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 19
Аудитын зөвлөмж ........ 20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 20
4. Менежментийн захидал ........ 21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 23

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн эмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 1-6/245

танай_____________-ны №_____________-т

САЙНШАНД СУМЫН 7-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.БАТГЭРЭЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Аудитын гол асуудал**

*Аудитын явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд*

1. Ажилчдад цалингийн нэмэгдлийг олгохдоо 1020.9 мянган төгрөгөөр илүү олгосон
2. Авлага өр төлбөрийн 8057.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй байсан

3. Цалингийн зардлаас 170. 0мянган төгрөгийн хог хаягдлын хураамж төлж батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулсан.
4. Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-ыг илүү дутуу тооцож тайлагнаж баталгаажуулсан

Нийт илэрсэн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг түшингээс хэтэрсэн байх тул

Төсвийн тухай хуулийн 16.5 заалтыг зөрчсөн байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **36,818,423.36** | **47,201,773.36** |
| **33** | **АВЛАГА** | 8,057,269.00 | 8,057,269.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 6,885,612.00 | 6,885,612.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,171,657.00 | 1,171,657.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,171,657.00 | 1,171,657.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 28,761,154.36 | 39,144,504.36 |
| **351** | **Түүхий эд материал** | - | 3,476,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 3,276,000.00 |
| 35130 | Эм боох материал | - | 200,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,761,154.36 | 35,668,504.36 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 239,600.00 | 487,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,809,249.29 | 31,469,749.29 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.07 | 0.07 |
| 35450 | Барилгын засварын материал | 30,000.00 | 30,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 723,105.00 | 722,055.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,959,200.00 | 2,959,200.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **605,186,822.71** | **574,069,454.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 605,186,822.71 | 574,069,454.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 552,602,822.71 | 520,046,287.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 507,848,490.00 | 507,848,490.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (20,313,939.60) | (40,627,879.20) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 48,873,785.00 | 54,938,285.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,660,674.54) | (36,522,343.19) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 101,781,380.26 | 102,081,380.26 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (58,690,177.71) | (68,348,104.16) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 20,015,000.00 | 20,015,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (19,912,499.66) | (20,000,000.00) |
| 39217 | Ном | 661,458.96 | 661,458.96 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 52,584,000.00 | 54,023,166.72 |
| 39301 | Програм хангамж | - | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (287,833.28) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 52,584,000.00 | 52,584,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **642,005,246.07** | **621,271,227.75** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9,614,459.31** | **6,736,594.59** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 9,614,459.31 | 6,736,594.59 |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 9,614,459.31 | 5,954,350.19 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 5,954,350.19 |
| **4136** | **Бусад өглөг** | 9,614,459.31 | 782,244.40 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 9,614,459.31 | 782,244.40 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **632,390,786.76** | **614,534,633.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 632,390,786.76 | 614,534,633.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 480,946,136.05 | 480,946,136.05 |
| 51101 | Өмч: - төрийн | 480,946,136.05 | 480,946,136.05 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 26,053,659.09 | 8,197,505.49 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 26,053,659.09 | 26,053,659.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (17,856,153.60) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 125,390,991.62 | 125,390,991.62 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **642,005,246.07** | **621,271,227.75** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **440,564,600.00** | **514,831,710.24** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **6,975,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 6,975,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 6,975,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 6,975,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **440,564,600.00** | **507,856,210.24** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 407,180,500.00 | 465,241,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 407,180,500.00 | 465,241,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | 2,585,828.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 585,828.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,384,100.00 | 40,028,682.24 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,384,100.00 | 40,028,682.24 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **498,236,213.31** | **532,687,863.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **498,236,213.31** | **532,687,863.84** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 498,136,213.31 | 524,496,234.50 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 275,261,148.82 | 366,550,368.43 |
| 210101 | Үндсэн цалин | 228,717,895.24 | 228,982,101.91 |
| 210102 | Нэмэгдэл | 16,171,670.58 | 99,453,457.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 8,431,755.55 |
| 210104 | Урамшуулал | 30,371,583.00 | 29,683,053.03 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,310,704.94 | 53,283,181.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,310,704.94 | 38,699,681.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 3,645,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 2,916,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 729,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 7,291,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,147,124.91 | 30,637,056.64 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,123,591.00 | 4,406,789.24 |
| 210302 | Түлш, халаалт | 25,653,197.91 | 17,819,427.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,370,336.00 | 8,408,440.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 2,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,326,726.00 | 10,179,940.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,597,900.00 | 1,542,940.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 235,016.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 105,800.00 | 225,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 28,200.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 365,000.00 | 2,260,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,994,810.00 | 5,588,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 63,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,285,250.00 | 21,878,920.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 266,870.00 | 730,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,018,380.00 | 20,872,420.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 276,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,434,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 34,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 302,500.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,097,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 190,000.00 | 184,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 190,000.00 | 184,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 642,100.00 | 920,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 442,100.00 | 670,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 250,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 51,973,158.64 | 39,428,768.32 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 199,200.00 | 219,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 51,773,958.64 | 39,208,868.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 100,000.00 | 8,191,629.34 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 100,000.00 | 250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | 250,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 585,829.38 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 0.69 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 585,828.69 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 7,355,800.65 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,355,800.65 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(57,671,613.31)** | **(17,856,153.60)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(57,671,613.31)** | **(17,856,153.60)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **440,564,600.00** | **507,856,210.24** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **440,564,600.00** | **507,856,210.24** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 407,180,500.00 | 465,241,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 407,180,500.00 | 465,241,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | 2,585,828.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 585,828.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,384,100.00 | 40,028,682.24 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,384,100.00 | 40,028,682.24 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **436,234,600.00** | **506,740,210.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **436,234,600.00** | **506,740,210.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **434,074,553.15** | **498,548,580.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 295,268,000.00 | 364,585,199.35 |
| 210101 | Үндсэн цалин | 239,794,400.00 | 217,198,799.43 |
| 210102 | Нэмэгдэл | 21,995,200.00 | 99,453,457.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 4,042,292.00 |
| 210104 | Урамшуулал | 33,478,400.00 | 43,890,649.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,940,153.15 | 49,219,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,469,053.15 | 34,635,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,694,200.00 | 3,645,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,117,800.00 | 2,916,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 423,600.00 | 729,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,235,500.00 | 7,291,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,064,100.00 | 39,528,681.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,123,591.00 | 4,406,789.24 |
| 210302 | Түлш, халаалт | 15,570,173.00 | 26,569,804.31 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,370,336.00 | 8,552,088.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,874,900.00 | 11,164,130.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 200,000.00 | 500,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 195,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 115,000.00 | 461,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 56,330.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 328,000.00 | 2,807,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,836,900.00 | 6,839,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 46,143,900.00 | 25,674,970.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 150,000.00 | 1,007,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,493,900.00 | 20,917,970.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 3,750,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,990,000.00 | 5,834,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 670,000.00 | 1,734,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,320,000.00 | 2,300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 190,000.00 | 184,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 190,000.00 | 184,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,303,500.00 | 920,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,103,500.00 | 670,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 250,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,300,000.00 | 1,438,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,300,000.00 | 1,438,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,160,046.85** | **8,191,629.34** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 100,000.00 | 250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | 250,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,060,046.85 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,060,046.85 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 585,828.69 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 0.69 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 585,828.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 7,355,800.65 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,355,800.65 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,330,000.00** | **1,116,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **1,116,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **1,116,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 1,116,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 816,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 300,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(1,116,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 4,330,000.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **20 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 157,098,488.00 | 125,390,991.62 | 80,308,427.40 | 362,797,907.02 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 3,416,845.00 | 3,416,845.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **157,098,488.00** | **125,390,991.62** | **83,725,272.40** | 366,214,752.02 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| **20 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **480,946,136.05** | **125,390,991.62** | **26,053,659.09** | 632,390,786.76 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (17,856,153.60) | (17,856,153.60) |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **480,946,136.05** | **125,390,991.62** | **8,197,505.49** | 614,534,633.16 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 526,773,100.00 | 505,270,382.24 | 21,502,717.76 | 95.92 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 526,773,100.00 | 505,270,382.24 | 21,502,717.76 | 95.92 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 526,523,100.00 | 497,664,580.90 | 28,858,519.10 | 94.52 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 364,585,200.00 | 364,585,199.35 | 0.65 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 217,198,800.00 | 217,198,799.43 | 0.57 | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 104,165,600.00 | 99,453,457.94 | 4,712,142.06 | 95.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,200,000.00 | 4,042,292.00 | 1,157,708.00 | 77.74 |
| 210104 | Урамшуулал | 38,020,800.00 | 43,890,649.98 | (5,869,849.98) | 115.44 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,219,000.00 | 49,219,000.00 | - | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,635,500.00 | 34,635,500.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,645,800.00 | 3,645,800.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,916,600.00 | 2,916,600.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 729,400.00 | 729,400.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,291,700.00 | 7,291,700.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,057,400.00 | 39,528,681.55 | 3,528,718.45 | 91.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,593,600.00 | 4,406,789.24 | 1,186,810.76 | 78.78 |
| 210302 | Түлш, халаалт | 27,561,700.00 | 26,569,804.31 | 991,895.69 | 96.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,902,100.00 | 8,552,088.00 | 1,350,012.00 | 86.37 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,098,800.00 | 10,964,130.00 | 134,670.00 | 98.79 |
| 210401 | Бичиг хэрэг | 500,000.00 | 500,000.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,000.00 | 300,000.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 472,000.00 | 461,000.00 | 11,000.00 | 97.67 |
| 210404 | Ном, хэвлэл | 180,000.00 | 56,330.00 | 123,670.00 | 31.29 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,807,800.00 | 2,807,800.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,839,000.00 | 6,839,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 50,764,100.00 | 25,674,970.00 | 25,089,130.00 | 50.58 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,007,000.00 | 1,007,000.00 | - | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,975,100.00 | 20,917,970.00 | 25,057,130.00 | 45.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,782,000.00 | 3,750,000.00 | 32,000.00 | 99.15 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,150,000.00 | 5,150,000.00 | - | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,550,000.00 | 2,550,000.00 | - | 100.00 |
| 210602 | Тавилга | 300,000.00 | 300,000.00 | - | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,800,000.00 | 1,800,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 | - | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 290,000.00 | 184,000.00 | 106,000.00 | 63.45 |
| 210702 | Дотоод албан томилолт | 290,000.00 | 184,000.00 | 106,000.00 | 63.45 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 920,000.00 | 920,000.00 | - | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 670,000.00 | 670,000.00 | - | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,438,600.00 | 1,438,600.00 | - | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,438,600.00 | 1,438,600.00 | - | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 250,000.00 | 7,605,801.34 | (7,355,801.34) | 3,042.32 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 250,000.00 | 250,000.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,000.00 | 250,000.00 | - | 100.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | | 0.69 | 0.69 | |
| 213403 | Төвлөрүүлэн шилжүүлэг | | 0.69 | 0.69 | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт .шилжүүлэг | | 7,355,800.65 | 7,355,800.65 | |
| 213503 | Төвлөрүүлэн шилжүүлэг | | 7,355,800.65 | 7,355,800.65 | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 526,773,100.00 | 505,270,382.24 | 21,502,717.76 | 95.92 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 483,215,700.00 | 465,241,700.00 | 17,974,000.00 | 96.28 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 483,215,700.00 | 465,241,700.00 | 17,974,000.00 | 96.28 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 43,557,400.00 | 40,028,682.24 | 3,528,717.76 | 91.90 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 43,557,400.00 | 40,028,682.24 | 3,528,717.76 | 91.90 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 31.00 | 31.00 | | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 15.00 | | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 15.00 | 15.00 | | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **2,585,828.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,585,828.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 2,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 1,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 1,800,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 585,828.00 |
| **2131** | **Олгосон санхүүжилт** | | 585,828.00 |
| 213101 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 585,828.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 2,585,828.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 2,585,828.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 585,828.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг М.Батгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 08-наас 2021 оны 02 дугаар сарын 24–ний хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Есөнхангай Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүээр сарын 22-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон шинэчлэлт өөрчлөлт гараагүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн удирдлага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн аудитын албанаас тайлант хугацаанд 2018-2019 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийж, 14 зөрчилд 9,483.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, үүнээс 4,212.6 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулж 5,271.1 мянган төгрөгийн төлбөрийг төлөөгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 532,226.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,644.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,734.0 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 8,057.3 | 8,057.3 | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 28,761.2 | 39,144.5 | 10,383.3 |
| Үндсэн хөрөнгө | 605,186.8 | 574,069.4 | (31,117.4) |
| **Нийт хөрөнгө** | 642,005.3 | 621,271.2 | (20,734.0) |
| Өр төлбөр | 9,614.5 | 6,736.6 | (2,877.9) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 632,390.8 | 614,534.6 | (17,856.1) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 642,005.3 | 621,271.2 | (20,734.0) |

Бараа материалын дансны үлдэгдэл 39,144,5 мянган төгрөг болж 10,383.3 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 3,476.0 мянган төгрөг, эм боох материал 200.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 247.9 мянган төгрөг, аж ахуйн материал 6,660.5 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 574,069.4 мянган төгрөг болж 31,117.4 мянган төгрөгөөр буурсан нь 6,064.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 300.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,727.0 мянган төгрөгийн программ хангамжаар тус тус нэмэгдэж, нийт 39,208.9 мянган төгрөгийн элэгдэл хорогдлын зардал тооцсон дүнгээр буурчээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 6,975.5 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 1,116.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,736.6 мянган төгрөг болж 2,877.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн үлдэгдэл 4,064.2 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын өглөгийн үлдэгдэл 1,890.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн ба байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэл 8,832.2 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 614,534.6 мянган төгрөг болж 17,856.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 74,267.1 мянган төгрөгөөр буюу 16.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны гүйцэтгэлийн үзүүлэлтээс улсын төсвийн санхүүжилт 58,061.2 мянган төгрөгөөр, орон нутгийн санхүүжилт 7,644.6 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл өмнөх оноос 34,451.6 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс өсч, нормативт зардал, ашиглалтын тогтмол зардал, НДШ-ийн зардал зэрэг буурсан байна. Энэ нь цалин хөлс, мөн төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгож эхэлсэнтэй холбоотойгоор зардал өсч, Ковидоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаа түр зогсч, байр ашиглалтын тогтмол зардал, хоол хүнсний зардал буурсан байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 346,321.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 346,321.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 180,451.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 526,773.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр 526,773.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 483,215.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 43,557.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 505,270.4 мянган төгрөгийн санхүүжилтээр орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 497,914.6 мянган төгрөгийг зарцуулж, 7,355.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 505,270.4 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь нормативт зардал 25,089.1 мянган төгрөгөөр, байрны ашиглалттай холбоотой зардал 3,528.7 мянган төгрөгөөр хэмнэсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сайншанд сумын Засаг даргын нөөц сангаас 2,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 585.28 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахуунд 200.0 мянган төгрөг, урсгал засварт 1,800.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 585.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,078.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 461.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,020.9 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 8,596.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийн 461.4 мянган төгрөгийн элэгдлийг тооцоогүй байсныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 10,200.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,020.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

Багш ажилчдад ур чадвар, үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаалаарх хувь хэмжээнээс илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т “Батлагдсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4-т “... гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, 20.2.5-д “Нягтлан бодогч нь дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах үүрэг хүлээнэ” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байх, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 8,596.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Балансын данстай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт:*
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 2015-2019 онд үүссэн 3 харилцагчийн 7,471.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Мөн тайлант хугацаанд 5,954.4 мянган төгрөгийн татвар, НД-ын өр үүссэн байна.

*1.2.* *Эрсдэл:*
Өр авлагын дүн буурахгүй байх, бүртгэлээр тавих хяналт сулрах

*1.3.* *Өгсөн зөвлөмж*:
Авлага, өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах. Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг мөрдөж ажиллах.

*1.4.* *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
Байгууллагын эрхлэгч, ня-бо нар хүлээн зөвшөөрсөн болно.

*2.Дотоод хяналттай холбоотой асуудал.*

*2.1. Илрүүлэлт:*

Цалингийн зардал нь НД-ын байгууллага, татварын албанд тайлагнасан цалингаас зөрүүтэйгээр тайлагнагдсанаас НДШ-ийн өр дутуу тусгагдсан, татварын авлагын үлдэгдэл дансны үлдэгдэлтэй тохирохгүй байна.

*2.2. Эрсдэл*:

Авлага өр төлбөрийн үлдэгдэл алдаатай илэрхийлэгдэх, хүү торгуулийн эрсдэлд орох

*2.3. Өгсөн зөвлөмж:*

Тайлант хугацааны эцэст цалинг хянаж, ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцоог хийж, татвар, НД-ын байгууллагуудад үнэн зөв тайлагнах, үлдэгдлийн зөрүүг арилгах.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Байгууллагын эрхлэгч, ня-бо нар хүлээн зөвшөөрсөн болно.

*3.Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:*
Төсвийн ангилал зөрчин цалингийн зардлаас хогны татвар төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг зөрчсөн.

*3.2. Эрсдэл*:

Хууль тогтоомж зөрчигдөж, төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулах.

*3.3. Өгсөн зөвлөмж:*

Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Байгууллагын эрхлэгч, ня-бо нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021.02.24 | | | ДГА-2021/70/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Дорноговь аймгийн Сайншанд сумын 7-р цэцэрлэг | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 2015-2019 онд үүсдэн 3 харилцагчийн 7,471.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Мөн тайлант хугацаанд 5,954.4 мянган төгрөгийн татвар, НД-ын өр үүссэн байна. | 7,471.4 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч Нягтлан бодогч | М.Батгэрэл Б.Адъяа |
| 2 | Шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийн 461.4 мянган төгрөгийн элэгдлийг тооцоогүй. | 461.4 | Залруулах | Эрхлэгч Нягтлан бодогч | М.Батгэрэл Б.Адъяа |
| 3 | Төсвийн ангилал зөрчин цалингийн зардлаас хогны татвар төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг зөрчсөн. | 170.0 | Албан шаардлага | Эрхлэгч Нягтлан бодогч | М.Батгэрэл Б.Адъяа |
| 4 | Эрхлэгчийн баталсан тушаалын дагуу нэмэгдэл олгосон эсэхийг тулган баталгаажуулахад 1020.9 мянган төгрөгийн нэмэгдэл илүү олгосон байна. | 1020.9 | Төлбөрийн акт тавих | Эрхлэгч Нягтлан бодогч | М.Батгэрэл Б.Адъяа |
| 5 | НД-д 391.0 мянган төгрөгийн цалин дутуу тайлагнаснаас НДШ 93.8 мянган төгрөгийн НДШ-ийн өр бүртгэгдээгүй. | 93.8 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч Нягтлан бодогч | М.Батгэрэл Б.Адъяа |
| 6 | Цалингийн зардал нь НД-ын байгууллага, татварын албанд тайлагнасан цалингаас зөрүүтэйгээр тайлагнагдсанаас НДШ-ийн өр дутуу тусгагдсан, татварын авлагын үлдэгдэл дансны үлдэгдэлтэй тохирохгүй байна. | 861.3 | Зөвлөмж өгөх | Эрхлэгч Нягтлан бодогч | М.Батгэрэл Б.Адъяа |
| **ДҮН** | | **10,078.8** | | | |